



ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2024 оны 02 сарын 28 өдөр

Дугаар А/154

Арвайхээр сум

Хөрөнгө зарцуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2023 оны 11 дүгээр сарын 30-ны өдрийн “Зорилтот жил зарлах тухай” 23/10 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. “Цахим шилжилтийг эрчимжүүлэх” зорилтот жилийн хүрээнд Төв аймгийн Дэлгэрхаан сумаас Өвөрхангай аймгийн Баян-Өндөр сум чиглэлийн газрын 2,5 км шилэн кабелийг шинэчлэх ажилд 19,960,000 (арван есөн сая есөн зуун жаран мянга) төгрөгийг хавсралтаар баталж, зарцуулсугай.

2. Дээрх 19,960,000 (арван есөн сая есөн зуун жаран мянга) төгрөгийг орон нутгийн төсөвт батлагдсан “Цахим шилжилтийг эрчимжүүлэх” зорилтот жилийн ажлын зардлаас санхүүжүүлэхийг аймгийн Засаг даргын Тамгын газар (Ц.Ганболд)-т зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА



И.ДОРЖСҮРЭН

6224 11 0336

Аймгийн Засаг даргын 2024 оны, дугаар
сарын-ны өдрийн дугаар
захирамжийн хавсралт



ЗАРДЛЫН ТООЦОО

№	Нэр төрөл	Тоо хэмжээ	Нэгжийн үнэ (төгрөг)	Нийт үнэ (төгрөг)
1	Газрын шилэн кабель	2500м	2,600	6,500,000
2	Аваарын тууз	2600м	100	260,000
3	Сувагчлал татах, булах ажлын хөлс, техникийн зардал	2500м	5,000	12,500,000
4	Тээврийн зардал	1	300,000	300,000
5	Томилолтын зардал	5 хүн	80,000	400,000
Нийт				19,960,000

-оОо-